

Аудитын код: САГ-2018/17/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.9.2	Авлага, өглөгийн талаар.....	5
2.9.3	Санхүүгийн тайлагналын талаар.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
2.16	Аудитын үр өгөөжийн бүртгэл	6
3	Менежментийн захидал	7
3.1	Санхүүгийн тайлагналын талаар.....	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	9
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	9
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан.....	11
5	Аудитын хураангуй тайлангийн хавсралт	13



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.АВИД ТАНАА

2018.03.23 № 01/813
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шинжлэх ухааны академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухааны академийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.101\2018\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323\SAG29.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071438

Аудитын гол асуудал

Шинжлэх ухааны академийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 756.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн, 229.7 сая төгрөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Шинжлэх ухааны академийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Шинжлэх ухааны академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчид Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа цаглабарт хугацаанд ирүүлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Шинжлэх ухааны академийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 6-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Шинжлэх ухааны академийн Эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Шинжлэх ухааны академийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Шинжлэх ухааны академийн 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 1/92 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шинжлэх ухааны академи нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Шинжлэх ухааны академи нь шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллагын хувьд монголын эрдэмтдийн төлөөллийг бүрэн хамарч эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага арга зүйгээр ханган ажилладаг.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;
- Шинжлэх ухаан, технологийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах;
- Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадлагаа хийх;
- Салбарын шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, түвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх;
- Эрдмийн зэрэг цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх

Дээрх зорилтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухааны академийн эрхзүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Шинжлэх ухааны академийн дүрэм болон бусад хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, салбарын болон хувийн секторын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудтай хамтран ажиллаж байна.

Шинжлэх ухааны академийн харьяанд Физик, технологийн, Одон орон, геофизикийн, Хими, химийн технологийн, Ерөнхий болон сорилын биологийн, Газарзүй, гео-экологийн, Палеонтологи, геологийн, Хэл зохиолын, Түүх, археологийн, Философийн, Олон улсын харилцааны, нийт 10 хүрээлэн 1085 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.


Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Шинжлэх ухааны академийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 23 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/



Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шинжлэх ухааны академийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Шинжлэх ухааны академи нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинжлэх ухааны академийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын алба байхгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Шинжлэх ухааны академи нь 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 13,938.6 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 13,859.3 сая төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь улсын төсвийн санхүүжилт дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд улсын төсвийн санхүүжилт 79.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдэн, үндсэн үйл ажиллагаанаас 141.9 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны 73.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 5.0 сая төгрөг буюу 0.7 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 1.0 сая төгрөг буюу 0.3 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.


Урсгал шилжүүлэг 40.2 сая төгрөг буюу 9.8 хувиар, үндсэн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 19.3 сая төгрөг буюу 0.2 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 18.3 сая төгрөг буюу 1.6 хувиар, хангамж, бараа материалын зардал 2.7 сая төгрөг буюу 1.3 хувь, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 2.1 сая төгрөг буюу 0.4 хувь, томилолт, зочны зардал 2.0 сая төгрөг буюу 1.5 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухааны академи нь Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг болон худалдан авах ажиллагааны тайлан, жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 23 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Шинжлэх ухааны академийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 10 хүрээлэнгийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар Одон орон, геофизикийн, Философийн, Хими, хими технологийн хүрээлэнгүүд “Хязгаарлалттай”, бусад хүрээлэнгүүд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Шинжлэх ухааны академийн 2017 оны үндсэн хөрөнгийн бүртгэлд 756.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ 2017 онд 359.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр, 304.1 сая төгрөгийн хөрөнгийг Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухаан технологийн сангийн албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу худалдан авсан,
- ✓ Баянхонгор аймгийн Богд суман дахь 10.6 сая төгрөгийн өртөг бүхий конторын барилга, 5 машины гараш, хүлэмж, агуулах, трактор, чиргүүл зэрэг хөрөнгө ашиглалтгүй,
- ✓ Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд байрлалтай Физик технологийн, Хими, хими технологийн, Биологийн хүрээлэнгүүдийн барилгыг тойруулан барьсан 81.0 сая төгрөгийн хашааг үндсэн хөрөнгөд бүртгэсэн,
- ✓ 1.2 сая төгрөгийн номын фонд биетээр байхгүй,
- ✓ Ашиглагдахгүй байгаа хөрөнгийн элэгдлийг тооцож зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, ... ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон ... үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т “... төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах”,

“Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, ... шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”, 3.1-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, ... үнэ төлбөргүй шилжүүлж авах ... журмаар олж авна”, 4.2-т “... улсын төсвийн хөрөнгө оруулалт ... үл хөдлөх хөрөнгө олж авбал тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэж, уг хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэ зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмыг хэрэгжүүлэх, албан шаардлага хүргүүлэх;

2.9.2 Авлага, өглөгийн талаар

2017 оны жилийн эцсийн байдлаар 229.7 сая төгрөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. Үүнд:

- ✓ Авлагын 11.5 хувь буюу 133.7 сая төгрөгийг,
- ✓ Урьдчилж гарсан зардлын 38.7 хувь буюу 73.8 сая төгрөгийг,
- ✓ Өглөгийн 47.8 хувь буюу 22.2 сая төгрөг байна.
- ✓ Арилжааны банкинд байрших 10 харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч ...", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...", 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэх;

2.9.3 Санхүүгийн тайлагналын талаар

Шинжлэх ухааны академийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 11 байгууллагын тайлан нэгтгэгддэг бөгөөд 9 байгууллага Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу " ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ... " гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа цаглабарт хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах зөвлөмж хүргүүлэх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


Шинжлэх ухааны академийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар эрдэм шинжилгээний ажлын зардал, төслийн үр дүн, бий болсон биет болон биет бус хөрөнгийн бүртгэл зэргийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Шинжлэх ухааны академийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,824.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 1,057.9 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 6.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 991.6 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 768.5 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж хүргүүлсэн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шинжлэх ухааны академийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн зардлын аудитаар 8 зөвлөмж өгөгдсөн ба эдгээрээс тус бүр 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.



2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Шинжлэх ухааны академийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 17,836.0 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 178.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Шинжлэх ухааны академийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинжлэх ухааны академийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 756.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн, 229.7 сая төгрөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Шинжлэх ухааны академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН БҮРТГЭЛ

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага өглөг, бараа материал, үндсэн хөрөнгийн болон бусад дансдад горим, нарийвчилсан сорил хэрэгжүүлсэн ба илэрсэн зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн болно.

Шинжлэх ухааны академи нь албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласнаар 985.7 сая хүртэлх төгрөгийн үр өгөөж бий болно гэж урьдчилан тооцоолж байна.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шинжлэх ухааны академийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Санхүүгийн тайлагналын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Шинжлэх ухааны академийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 11 байгууллагын тайлан нэгтгэгддэг бөгөөд 9 байгууллага Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “ ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ... ” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлан хуулийн хугацаанд гаргахгүй байх:

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангаа цаглабарт хугацаанд ирүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/


Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3а, 3б	2,986.8	2,598.8
Авлага	5а, 5б, 6а, 6б	891,820.1	1,164,004.2
Урьдчилж төлсөн зардал	7а, 7б	102,613.3	190,819.9
Бараа материал	8а, 8б, 8в	965,814.6	1,335,625.0
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,963,234.8	2,693,047.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	12а, 12б, 12в	13,425,025.1	13,000,788.2
Биет бус хөрөнгө	13	517,539.2	441,969.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		13,942,564.3	13,442,757.6
ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		15,905,799.1	16,135,805.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б		
Өглөг	17а, 17б	31,556.8	46,448.5
Богино хугацаат өр төлбөрийн дүн		31,556.8	46,448.5
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		31,556.8	46,448.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ			
Засгийн газрын хувь оролцоо		15,874,242.3	16,089,356.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		15,874,242.3	16,089,356.9
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН НИЙТ ДҮН		15,905,799.1	16,135,805.4

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
Татварын бус орлого /хураамж, өмчийн орлого, торгууль/	1а, 1б	213,671.2	1,505,058.4
Буцалтгүй тусламжийн орлого	1а, 1б	16,787,593.1	16,559,583.2
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН НИЙТ ДҮН		17,001,264.3	18,064,641.6
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
УРСГАЛ ЗАРДАЛ			
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж		10,803,558.4	10,532,770.4
Татаас болон шилжүүлгийн төлбөр		112,769.5	85,679.7
Бараа, үйлчилгээний зардал		423,848.3	351,672.5
Нийгмийн хамгааллын зардал		32,686.8	374,595.9
Элэгдэл, хорогдлын зардал		1,483,480.7	1,285,397.4
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал		4,964,839.8	5,205,923.2
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	2а, 2б	17,821,183.5	17,836,039.2
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг/(алдагдал)		(819,919.2)	228,602.4
Үндсэн хөрөнгө борлуулсны олз (гарз)			12,531.1
Үндсэн бус үйл ажиллагааны орлого (зардал)-ын нийт дүн			12,531.1
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)			(819,919.2)



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,698,431.3	-	16,698,431.3
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	2,134.9	-	2,134.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,696,296.4	-	16,696,296.4
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	(2,134.9)	-	(2,134.9)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	(819,919.2)	-	(819,919.2)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,874,242.3	-	15,874,242.3
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	64,998.7	-	64,998.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,939,241.0	-	15,939,241.0
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	(65,955.4)	-	(65,955.4)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	216,071.3	-	216,071.3
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,089,356.9	-	16,089,356.9

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Татварын бус орлого /хураамж, өмчийн орлого, торгууль/	345,477.1	1,304,708.5
Буцалтгүй тусламжийн орлого	17,619,626.8	16,389,288.6
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	17,965,103.9	17,693,997.1
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	10,978,484.7	10,647,349.4
Татаас болон шилжүүлгийн төлбөр	835,510.8	1,071,323.0
Бараа, үйлчилгээний зардал	418,692.5	289,085.5
Нийгмийн хамгааллын зардал	32,686.8	374,596.0
Үйл ажиллагааны бусад зардал	5,224,383.8	4,933,269.6
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	17,489,758.6	17,315,623.5
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	475,345.3	378,373.6
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт	477,967.0	378,761.6
Хөрөнгө оруулалт цэвэр мөнгөн гүйлгээ	477,967.0	378,761.6
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	(2,621.7)	(388.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,608.5	2,986.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,986.8	2,598.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ**

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,978.8	2,978.8	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,938,552.4	13,859,297.9	79,254.5	99.4
УРСГАЛ ЗАРДАЛ	13,938,552.4	13,859,297.9	79,254.5	99.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,521,273.6	13,482,431.4	38,842.2	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,229,994.4	10,210,734.0	19,260.4	99.8
Үндсэн цалин	8,724,681.3	9,351,631.9	-	107.2
Нэмэгдэл	986,562.8	607,197.3	379,365.5	61.5
Унаа хоолны хөнгөлөлт	518,750.3	251,904.8	266,845.5	48.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,153,361.5	1,135,048.8	18,312.7	98.4
Тэтгэврийн даатгал	742,088.4	775,215.1	-33,126.7	104.5
Тэтгэмжийн даатгал	107,158.6	86,873.5	20,285.1	81.1
ҮОМШӨ-ний даатгал	79,954.1	78,715.3	1,238.8	98.5
Ажилгүйдлийн даатгал	21,106.0	20,255.1	850.9	96.0
Эрүүл мэндийн даатгал	203,054.4	173,989.7	29,064.7	85.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	537,869.4	535,790.0	2,079.4	99.6
Гэрэл, цахилгаан	245,559.3	269,950.3	-24,391.0	109.9
Түлш, халаалт	221,925.5	195,700.6	26,224.9	88.2
Цэвэр, бохир ус	37,616.9	38,104.7	-487.8	101.3
Байрны түрээс	32,767.7	32,034.3	733.4	97.8
Хангамж, бараа материалын зардал	205,801.3	203,111.6	2,689.7	98.7
Бичиг хэрэг	14,385.0	17,268.9	-2,883.9	120.0
Тээвэр, шатахуун	19,270.4	14,977.9	4,292.5	77.7
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	43,134.3	37,546.8	5,587.5	87.0
Ном, хэвлэл	90,154.0	90,160.6	-6.6	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,118.6	6,608.1	-1,489.5	129.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,739.0	36,549.3	-2,810.3	108.3
Нормативт зардал	7,613.0	7,607.9	5.1	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,613.0	7,607.9	5.1	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	377,472.6	378,482.2	-1,009.6	100.3
Багаж, техник, хэрэгсэл	225,453.3	225,154.5	298.8	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,050.0	3,057.8	-7.8	100.3
Урсгал засвар	148,969.3	150,269.9	-1,300.6	100.9
Томиллолт, зочны зардал	139,537.2	137,494.2	2,043.0	98.5
Дотоод албан томиллолт	139,537.2	137,494.2	2,043.0	98.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	757,053.0	762,062.5	-5,009.5	100.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	741,254.0	747,370.3	-6,116.3	100.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,300.0	2,300.0	0.0	100.0
Даатгалын үйлчилгээ	2,195.6	2,141.7	53.9	97.5
Тээврийн хэрэгслийн татвар	1,833.0	1,302.5	530.5	71.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	338.5	214.5	124.0	63.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000.0	3,000.0	0.0	100.0
Газрын төлбөр	6,011.9	5,708.5	303.4	95.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120.0	25.0	95.0	20.8
Бараа үйлчилгээний бусад зардал	112,571.2	112,100.3	470.9	99.6
Бараа үйлчилгээний бусад зардал	4,760.4	4,760.4	0.0	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107,810.8	107,339.9	470.9	99.6

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	417,278.8	376,866.5	40,412.3	90.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,745.5	7,570.5	175.0	97.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	7,745.5	7,570.5	175.0	97.7
Бусад урсгал шилжүүлэг	409,533.3	369,295.9	40,237.4	90.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,820.5	8,811.1	9.4	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,212.8	59,602.9	609.9	99.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340,500.0	300,882.0	39,618.0	88.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,938,552.4	13,858,917.9	79,634.5	99.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,716,187.4	13,643,893.9	72,293.5	99.5
Улсын төсвөөс санхүүжих	13,716,187.4	13,643,893.9	72,293.5	99.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	222,365.0	215,024.0	7,341.0	96.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,425.0	141,852.9	14,572.1	90.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,940.0	73,171.1	-7,231.1	111.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,598.8	-2,598.8	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	11	11	-	100.0
Төсвийн байгууллага	11	11	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1186	1169	-17	98.6
Удирдах ажилтан	68	69	1	101.5
Гүйцэтгэх ажилтан	924	902	-22	97.6
Үйлчлэх ажилтан	194	198	4	102.1

5 АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2017 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2018/17 /СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шинжлэх ухааны академи			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	663.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн, Баянхонгор аймаг дахь 10.6 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгө ашиглалтгүй байгаа, 81.0 сая төгрөгийн өөрийн эзэмшлийн бус хөрөнгийг данс бүртгэлд 1.2 сая төгрөгийн номын фонд биетээр оршин байхгүй байна.	756.0	Албан шаардлага	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Б.Авид
				Захиргаа, санхүү, хэлтсийн дарга	А.Баярбаатар
2	2017 оны жилийн эцсийн байдлаар 229.7 сая төгрөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	229.7	Албан шаардлага	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Б.Авид
				Захиргаа, санхүү, хэлтсийн дарга	А.Баярбаатар
Нийт дүн		985.7			

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ